5.1 Төгсөлтийн бүртгэлийн үйл ажиллагаа

Төгсөлтийн бүртгэл

5-р ангийн төгсөлтийн бүртгэлийг сургалтын менежер баталгаажуулна.

9, 12-р анги төгсөгчдийн хувьд дараах дарааллын дагуу бүртгэлийг хөтөлж, баталгаажилт хийнэ.



Бүртгэлийн явцаас хамаарч төлөв нь дараах байдлаар өөрчлөгдөнө.

№	Үйл ажиллагаа	Төлөв
1	АУБ төгсөлтийн бүртгэл хийгээгүй.	Бүртгээгүй
2	АУБ төгсөлт бүртгэсэн.	Бүртгэсэн
3	АУБ төгсөлтийн бүртгэлийг Менежерт илгээсэн.	Илгээсэн
4	Менежер төгсөлтийн бүртгэлийг БСУГ/БХ –д илгээсэн.	Хянагдаж байгаа
5	БСУГ/БХ –ийн мэргэжилтэн төгсөлтийн бүртгэлийг хянасан.	Хянагдсан
6	БСУГ/БХ –ийн Дарга төгсөлтийн бүртгэлийг баталгаажуулсан. БҮ/БГ дугаар болон QR код олгогдоно.	Батлагдсан
7	Төгсөлтийн бүртгэл цуцлагдсан.	Цуцлагдсан

Сургууль дээрээс баталгаажуулах хүсэлт илгээхэд анхаарах зүйлс

- “Бүртгэлийн маягт” хянана.
- Суралцагч бүрээр төгсөлтийг баталгаажуулна.
- Сургуулиас дүүргийн БХ –т “Төгсөлт баталгаажуулах хүсэлт” илгээсэн үед дараах бүртгэлүүд засварлах боломжгүй болно.
    - Хичээлийн дүн
    - Судлагдахууны дүн
    - Төрөлжсөн эсхүл гүнзгийрүүлэн судалсан хичээлийн 7 хоногт судалсан цаг
    - Улсын шалгалтын дүн
    - Сурлагын үнэлгээний дундаж хувь
- Төгсөлт баталгаажуулах хүсэлт илгээх үед “Бүртгэлийн маягт” дүүргийн БХ –т давхар илгээгдэнэ.
- БСУГ/БХ -ийн дарга Суралцагч бүрээр төгсөлтийг баталгаажуулснаар Боловсролын баримт бичгийн QR код болон БҮ/БГ дугаарууд олгогдоно. Баталгаажилт хийгдсэний дараа Бүртгэлийн маягтыг татаж үзэхэд суралцагчдын нэрний харгалзах баганад Үнэмлэх, гэрчилгээний дугаар нөхөгдөж гарна.

5.2 Төгсөлтийн бүртгэл хөтлөх

Төгсөлтийн бүртгэл хөтлөх- Анги удирдсан багш

Ангийн багш нь төгсөлтийн модулийн тусламжтай бүртгэлээ хийнэ.

Ангийн багш нь төгсөлтийн бүртгэлээ хийгээд баталгаажуулах хүсэлтээ **Сургалтын менежер**-т илгээнэ.

Төгсөлтийн бүртгэл хөтлөх -өөс өмнө дараах ажлууд системд хийгдсэн байх шаардлагатай. Үүнд:

1. **Хичээлийн дүн** бүрэн оруулж баталгаажуулсан байх
2. **Судлагдахууны дүн** -г бүрэн бодсон байх
3. **Шалгалтын дүн** бүрэн оруулж баталгаажуулсан байх

Төгсөлтийн бүртгэл хөтлөх алхамчилсан дараалал нь дараах байдлаар шийдвэрлэнэ.

1. Ангийн багш үндсэн цэснээс **Төгсөлт** модулийг ашиглан бүлгийн суралцагчдынхаа төгсөлтийн бүртгэлээ хийнэ.
2. **Төгсөлтийн бүртгэл** гэсэн товч дээр дарж бүртгэлийн хуудасруу шилжинэ.
3. **Харах** / **Шинэчилэх** гэсэн товч дарж ангийн суралцагчдын жагсаалт харна.
4. **Төгсөлт бүртгэх** гэсэн товч дээр дарж бүртгэл хөтлөх талбар нээгдэнэ.



5. **Төгсөлтийн бүртгэл хөтлөх**